



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ**

2024 оны 12 сарын 24 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

“Дүүргийн Засаг даргын 2024-2028 оны
үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.1 дэх заалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1 дэх заалт, 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит III хуралдаанаас ТОГТООХ нь:

1. “Дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.

2. Дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дүүргийн Засаг дарга (Б.Цэрэн)-д даалгасугай.

2.1. Дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшний хамт баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах

2.2. Дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн дүүргийн төсөвт тусган хэрэгжүүлэх

3. Дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жил бүр танилцуулж ажиллахыг дүүргийн Засаг дарга (Б.Цэрэн)-д үүрэг болгосугай.

4. Дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, чиглэл өгч ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд даалгасугай.

ДАРГА



Ч.БАТ-ОРГИЛ

НЭГ. ТӨРИЙН АЛБАНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ – 20 МИНУТЫН ХОТЫН ШИЛЖИЛТ

1.1 Нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг зохистой түвшинд хүргэх бодлого төлөвлөлтийг хэрэгжүүлж, иргэд оршин сууж буй газраасаа 20 минутын зайд нийгмийн суурь үйлчилгээ авах боломжийг үе шаттайгаар бүрдүүлнэ.

1.1.1. Орон нутгийн зэрэглэлтэй “Хан-Уул”, “Яармаг”, “Буянт-Ухаа” хотууд шинээр байгуулах зохион байгуулалтын бэлтгэл ажлыг талуудын оролцоотойгоор хангана.

1.1.2. Хороодыг нэгтгэн зохион байгуулж 120 мянгат, Зайсан, Ээрмэл, Яармаг, Арцат, Буянт-Ухаа орчмыг хорооллын зохион байгуулалтад шилжүүлэх бэлтгэл хангана.

1.1.3. Шинээр байгуулагдах орон нутгийн зэрэглэлтэй “Хан-Уул”, “Яармаг”, “Буянт-Ухаа” хотуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг мэргэжлийн чиг үүргийн байгууллагуудтай хамтран боловсруулна.

1.1.4. Анхан шатны нэгжид чиг үүргийг шилжүүлэх замаар иргэдээс нийтлэг гардаг санал, хүсэлт, гомдлыг шууд бие даан шуурхай шийдвэрлэх зохион байгуулалтад шилжинэ.

1.1.5. Өрхийн эмнэлгүүдийн зарим зохион байгуулалтуудыг нэгтгэж хороолол бүрд “Эрүүл мэндийн төв” байгуулах ажлыг талуудтай хамтран үе шаттай зохион байгуулна.

1.1.6. Төрийн цахим үйлчилгээний “Хурдан цэг”-үүдийг иргэдэд ойрхон хүртээмжтэй байх зохион байгуулалт хийж ажиллуулна.

1.1.7. Хорооллын нутаг дэвсгэрийн аль ч цэгт цагдаагийн байгууллага дуудлага хүлээн авснаас хойш 20 минутад автомашинаар очих, хүртээмжтэй байх зохион байгуулалтыг цагдаагийн байгууллагатай хамтран шат дараатайгаар хийнэ.

1.1.8. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхэд багачууд оршин суугаа газраасаа 20 минутын зайд боловсролын үйлчилгээ авах боломжийг үе шаттайгаар бүрдүүлнэ.

1.2 Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

1.2.1. Хүний нөөцийн бодлого чиглэлийн хүрээнд төрийн албан хаагчдын “Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

1.2.2. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийн биелэлтийг хангуулах, төрийн албан хаагчдыг авлигын эрсдэл, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна.

1.2.3 Төрийн байгууллагуудын барилга байгууламж, алба хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, техник, тоног төхөөрөмж, тусгай хэрэгслээр хангах ажлыг хэрэгжүүлнэ.

1.2.4 Төрийн байгууллага, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг сайжруулах, үйлчилгээг цахимжуулахад дэмжлэг үзүүлнэ.

1.2.5 Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг цахимжуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэхэд хамтран ажиллана.

1.2.6. Төрийн архивын "Салбар архив" байгуулах ажлыг эхлүүлж, иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх архивын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.2.7. Дүүргийн салбар архив болон Засаг даргын Тамгын газрын архивт хадгалагдаж буй цаасан суурьт баримтыг цахим хэлбэрт шилжүүлнэ.

1.3. Иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

1.3.1. Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн камерын хяналтыг нэмэгдүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагын гадна орчны камерыг "Телехяналтын камерын дэд төв"-д холбох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

1.3.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, Цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх илрүүлэх чадавхыг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.

1.3.3. Иргэд, олон нийтэд хүргэх гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлж, Онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх чадавхыг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.

1.3.4. Замын хөдөлгөөнд оролцогчдын замын хөдөлгөөний соёлыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулна.

1.3.5. Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны хүрээнд орон нутгийн хамгаалалтын үндсэн арга хэмжээг хэрэгжүүлэх, хүүхэд залуучуудад эх оронч үзэл хүмүүжил олгох олон талт арга хэмжээг зохион байгуулж, иргэн цэргийн харилцааг бэхжүүлнэ.

ХОЁР. ЭКО ДҮҮРЭГ – НОГООН ХӨГЖИЛ

2.1. Төсвийн төлөвлөлтөд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж ил тод нээлттэй байдлыг сайжруулан төсвийн хөрөнгийг үр ашигтай, хариуцлагатай төлөвлөж хэрэгжүүлнэ.

2.1.1. Төсвийн төлөвлөлтөд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, саналыг тусган боловсруулж, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, үр дүнг иргэд, олон нийтэд ил тод мэдээллэж, санхүүгийн сахилга бат, хариуцлагыг өндөржүүлнэ.

2.1.2. Хувийн хэвшил, олон улсын байгууллага, төрийн бус байгууллагуудын санал санаачилгыг дэмжин тулгамдсан асуудлыг шийдэх үр ашигтай төсөл, хөтөлбөрүүдийг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.

2.1.3. Өмчийн бүртгэл, хяналтын менежментийг сайжруулах арга хэмжээ авч, өмч ашиглалтыг сайжруулан өмчийн үнэ цэнийг өсгөн үр ашгийг нэмэгдүүлнэ.

2.1.4. Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан ногоон худалдан авалт болон дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжинэ.

2.2. Жижиг, дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжинэ.

2.2.1 Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг гадаад, дотоодын зах зээлд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж, борлуулалтыг дэмжиж ажиллана.

2.2.2. "Хан-Уулд үйлдвэрлэв" борлуулалтын төвийг байгуулж, төвийн үйл ажиллагаагаар дамжуулан гарааны бизнес эрхлэгчдийг дэмжин ажиллана.

2.2.3. Худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын зориулалт бүхий төрөлжсөн гудамжтай болж, жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжин ажиллана.

2.2.4. Аялал жуулчлал, зочлох үйлчилгээ, худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, стандартыг хангуулна.

2.3. Хүнс, хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа эрхчлэгчдийг дэмжих, хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангуулах хяналтыг сайжруулах, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангах зорилтыг дэмжин хэрэгжүүлнэ.

2.3.1. Хүнсний ногоо тариалах, хүлэмжийн аж ахуйг кластер хэлбэрээр хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

2.3.2. Газар тариалан, хүлэмжийн аж ахуйн тариалалт, хадгалалт, борлуулалт, түгээлтийн сүлжээнд ургамлын эрүүл ахуй, хорио цээрийн шаардлагыг хангуулж хэрэглэгчдэд чанартай бүтээгдэхүүн нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

2.3.3. Дүүргийн мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрсөн бүсэд эрчимжсэн аж ахуйн үйлдвэрлэлийг ашиг шимийн чиглэлээр төрөлжүүлэн кластер хэлбэрээр хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

2.3.4. Мал, амьтны гоц халдварт, халдварт, шимэгчлэх, халдваргүй өвчнөөс урьдчилан сэргийлэх, тандалт шинжилгээ хийх, оношлох, эрүүлжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэн, нутаг дэвсгэрийн мал, амьтны өвчлөлийн эрсдэлийг бууруулна.

2.3.5 Хүнсний бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлт, үйлдвэрлэл, үйлчилгээний стандартыг хангуулж, иргэдийг эрүүл аюулгүй хүнсээр хангагдах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.3.6 Хүн амын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хүнсний зориулалтын бус савны хэрэглээг бууруулна.

2.4. Иргэд амарч, тухлах ногоон байгууламж бүхий тохилог орчинг байгуулж, иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.4.1. Иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн амарч, зугаалах, спортоор хичээллэх, чөлөөт цагаа өнгөрөөх нөхцөлийг хангасан, цэцэрлэгт хүрээлэн, бичил цэцэрлэгийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

2.4.2. Орон сууц, гэр хорооллын дунд болон нийтийн эзэмшлийн гудамж талбайд орчин үеийн шийдэл бүхий хүүхдийн тоглоомын талбай, спорт талбай байгуулна.

2.4.3. Нийтийн эзэмшлийн гудамж талбайд ашиглалтын хугацаа дууссан, эвдэрсэн эд хөрөнгө, тоглоомын талбай, спорт талбайг засварлаж, шинэчилж стандарт, орчны аюулгүй байдлыг хангуулна.

2.4.4. Нийтийн эдэлбэр газар болон цэцэрлэгт хүрээлэн, бичил цэцэрлэгүүдэд түшиглэн гоёл чимэглэлийн бут сөөг, олон наст цэцэгс, ховор ургамлын хослол зохиомж бүхий цэцэрлэгт гудамж, талбайг үе шаттайгаар байгуулна.

2.4.5 Нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх бодлого баримтлан иргэд, сургууль, цэцэрлэг, сууц өмчлөгчдийн холбоодод дэмжлэг үзүүлнэ.

2.4.6. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлж буй ойн төгөл байгуулах төсөл арга хэмжээг үргэлжлүүлж, тусгай хэрэгцээний ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.

2.4.7 Иргэд, аж ахуйн нэгжүүдийн оролцоотой хур усыг хуримтлуулах, хөв цөөрөм байгуулах, нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн усалгааны системийг нэвтрүүлж, зөөврийн усалгааг үе шаттайгаар хална.

2.5. Агаар, хөрс бохирдуулагч эх үүсвэрийг иргэдийн оролцоотойгоор бууруулж, байгальд ээлтэй хэрэглээг нэмэгдүүлнэ.

2.5.1. Гэр хорооллын айл өрхийн дулаан хангамжийг бусад эх үүсвэрт /төвлөрсөн дулаан, хий, сэргээгдэх эрчим хүч, цахилгаан болон бусад/ үе шаттай шилжүүлж, хатуу

түлшний хэрэглээг бууруулж, амины сууцны дулаан алдагдлыг бууруулахад иргэд, олон нийтийн үүрэг, оролцоог нэмэгдүүлнэ.

2.5.2. Иргэдийн оролцоотойгоор гэр хорооллын нүхэн жорлонгийн тоог үе шаттайгаар багасгаж, хөрсний бохирдлыг бууруулна.

2.5.3. Арьс шир боловсруулах үйлдвэр, авто засвар, томоохон зах худалдааны төв зэрэг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдээс үүдэлтэй хүнд металлын бохирдлыг бууруулна.

2.5.4. "Эмээлт эко аж үйлдвэрийн парк"-т арьс ширний үйлдвэрүүдийг нүүлгэж, үйлдвэрийн бүс орчмын хөрсний бохирдлыг арилгах, чөлөөлөгдсөн талбайд зам талбай ногоон байгууламж, нийгмийн дэд бүтцийн байгууламж төлөвлөн байгуулах цогц арга хэмжээг талуудтай хамтран эхлүүлнэ.

2.5.5. Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагааны улмаас бохирдсон, доройтсон, эвдэрсэн газар, газрын хэвлийг хоргүйжүүлэх, нөхөн сэргээх, хамгаалах ажлын үр дүнг дээшлүүлж, хариуцлагатай үйл ажиллагааг хэвшүүлнэ.

2.5.6. Гэр хорооллын бүсийн ус түгээх цэгийг нэмэгдүүлж, хуучин ус түгээх байрыг засварлан ухаалаг төхөөрөмж суурилуулж хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.5.7. Хот нийтийн аж ахуйн машин, механизм, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг үргэлжлүүлж, хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээнд технологийн шинэчлэл хийнэ.

2.5.8. Төвлөрсөн бус ариун цэврийн байгууламжийн лагийг байгальд ээлтэй аргаар устгах төсөл хэрэгжүүлнэ.

2.5.9. Хувийн хэвшилд суурилсан хог хаягдлын менежментийн тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлнэ.

2.6. Олон нийтийн нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.6.1. Хүүхдэд бага наснаас нь эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлж, өсвөр насныхны нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлнэ.

2.6.2. Урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн хамрагдалтыг 10 хувиар нэмэгдүүлж, зонхилон тохиолдох халдварт бус өвчлөлийг бууруулна.

2.6.3. Эх, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг бууруулах ажлыг зохион байгуулна.

2.6.4. Хүүхдүүдэд амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох, амны хөндийн өвчлөлийг эрүүлжүүлэн бууруулах "Эрүүл шүд-Эрүүл хүүхэд" арга хэмжээг зохион байгуулна.

2.6.5. Харьяа эрүүл мэндийн байгууллагуудын тоног төхөөрөмж болон бусад шаардлагатай хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, тусламж үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.6.6. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг зориулалтын тоног төхөөрөмж, өрөө тасалгаагаар хангаж, иргэд өдрийн эмчилгээ үйлчилгээ авах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

2.6.7. Бүх нийтээрээ эрүүл амьдралын хэв маягийг дэмжих дасгал хөдөлгөөн, спорт, нийтийн биеийн тамираар хичээллэх, эрүүл зөв хооллох дадлыг хэвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг тогтмол зохион байгуулна.

2.6.8. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоотойгоор спортын төрөлжсөн уралдаан тэмцээнийг улирал бүр зохион байгуулж, "Спортлог дүүрэг" /хот/ болно.

2.6.9. Хан-Уул спорт ордон болон бүс тус бүрд спорт заал байгуулан спортын барилга, байгууламжийн хүртээмжийг 1,000 хүнд 70 м²-д хүргэж нэмэгдүүлнэ.

2.7. Хүүхэд бүр чанартай боловсролыг тэгш, хүртээмжтэй эзэмших нөхцөлийг бүрдүүлж, суралцагчийн хөгжлийг бүх талаар дэмжинэ.

2.7.1. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдахаар хүсэлт гаргасан хүүхэд бүрийг бүрэн хамруулна

2.7.2. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт шаардлагатай тоног төхөөрөмж, материал хэрэгслийн дэмжлэг үзүүлж, сургалтын орчин, нөхцөлийг сайжруулна.

2.7.3. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд монгол бичиг, гадаад хэл болон байгалийн ухааны уралдаан тэмцээнүүдийг жил бүр зохион байгуулж, сургалтын чанарыг ахиулахад дэмжлэг үзүүлнэ.

2.7.4. Ерөнхий боловсролын сургуулиудад математик, физик, хими, гадаад хэлний төрөлжсөн кабинет байгуулах ажлыг шат дараатайгаар хэрэгжүүлнэ.

2.7.5. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын үдийн хоолонд сүү, сүүн бүтээгдэхүүн нэмэлтээр олгон хүүхдийн ясны бүтэц, өсөлт хөгжлийг дэмжих ажлыг хамтран хэрэгжүүлнэ.

2.8. Зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлнэ.

2.8.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг бизнес эрхлэх сургалт, арга хэмжээнд хамруулан, гарааны бизнес эрхлэлтэд дэмжлэг үзүүлнэ.

2.8.2 Зорилтот өрхийн хөдөлмөрийн насны ажилгүй иргэдийг төсөл бичих, мэргэжил эзэмшүүлэх сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

2.8.3 Оюутан, залуучууд, ахмад настны түр болон цагийн ажлын байрыг нэмэгдүүлж, ажлын байранд зуучлах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.9. Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийг дэмжиж, соёл болон хамгааллын олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.9.1. Аж ахуйн нэгж, байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөл, хүүхдийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, тэдгээрээс гарах санал санаачилгыг нутаг дэвсгэрийн Хүүхдийн төлөө зөвлөл, шийдвэр гаргах түвшинд хүргэж хүүхдийн нийгмийн амьдралд оролцох эрхийг хангана.

2.9.2. Хүүхдийн эрхийн зөрчил, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг үе шаттай зохион байгуулж хүүхдийн эрхийг хангана.

2.9.3. Өсвөр үе, залуучуудыг сөрөг зан үйл, хорт зуршил, цахим дээрэлхэлтээс ангид байх, хувь хүний хөгжлийг дэмжих сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулна.

2.9.4. Олон нийтэд соёлын боловсрол олгох цахим аян өрнүүлж, нөлөөллийн олон талт арга хэмжээг бүх шатны боловсрол, соёлын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

2.9.5. Соёлын ордны үйл ажиллагааг өргөжүүлж, урлаг, соёлын дугуйлан секцийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.9.6. Ашиглалтын шаардлага хангахгүй дүүргийн Соёлын ордны барилгыг дахин төлөвлөж соёл, урлагийн арга хэмжээг нэгдсэн байдлаар зохион байгуулах боломжтой барилга, байгууламжийг шинээр барина.

2.9.7. Шинэ тутам хөгжиж байгаа "Цахим спорт"-ын арга хэмжээг зохион байгуулна.

ГУРАВ. ДЭД БҮТЭЦ-ХОТ НИЙТИЙН АЖ АХУЙ

3.1 Иргэдийн амьдрах орчны хүртээмжийг сайжруулна.

3.1.1. Иргэдийн амьдрах орчны хүртээмжийг хангахад чиглэсэн хотын стандартын баримт бичгийг сурталчлан таниулах, нутаг дэвсгэрийн хэмжээнд мөрдүүлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлнэ.

3.1.2. Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд инженерийн болон нийгмийн дэд бүтцээр бүрэн хангагдсан орон сууцны хороолол барих төлөвлөлтийг талуудтай хамтран хэрэгжүүлнэ.

3.1.3. Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барилгажуулах ажлыг үргэлжлүүлж, айл, өрхийн орон сууцыг стандартын шаардлагад нийцүүлэх ажлыг хамтран хэрэгжүүлнэ.

3.1.4. Цагдаа, түргэн тусламж, гал унтраах, аврах ажиллагаа шуурхай хүрэх, нэвтрэх боломжийг бүрдүүлж, гэр хороолол болон зуслангийн бүсийн орц, гарц, орон сууцны хороолол дундах газар, нийтийн эзэмшлийн зам, талбайн газрын зөрчлийг арилгана.

3.1.5. Хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан дүүргийн "Газар зохион байгуулалтын төлөвлөгөө"-г жил бүр батлуулан хэрэгжилтийг хангуулж ажиллана.

3.2. Дэд бүтцийн хангамжийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар хүртээмжтэй байдлыг хангана.

3.2.1. Цахилгаан хангамжийн хуваарилах байгууламж, дэд өртөө барьж, гэрэл цахилгаангүй болон хүчдэлийн уналттай өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

3.2.2. Үер, усны эрсдэлтэй бүсэд далан суваг барих, зам талбайн ус зайлуулах сүлжээгүй хороолол, хотхонуудыг ус зайлуулах шугам сүлжээнд холбох арга хэмжээг зохион байгуулна.

3.2.3. Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шат, дээвэр, фасад, инженерийн шугам сүлжээг өргөтгөн шинэчлэх ажлыг мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн хэрэгжүүлж, иргэдийн ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

3.2.4. Гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх, ашиглалтын хугацаа дууссан гэрэлтүүлгийн толгой, шонг сэргээн засварлах, нэгдсэн удирдлагын автомат системд холбох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

3.3. Зам, замын байгууламжийн сүлжээг өргөтгөн хүртээмжийг нэмэгдүүлж түгжрэлийг бууруулахад дэмжлэг үзүүлнэ.

3.3.1. Нутаг дэвсгэрийн хөдөлгөөний эрчим их гол гудамж замуудын уулзварыг дахин төлөвлөж нэвтрүүлэх чадварыг сайжруулах ажлыг Улс, нийслэл, дүүргийн төсөв бусад хөрөнгийн эс үүсвэрээр барьж байгуулах ажлыг хамтран хэрэгжүүлнэ.

3.3.2. Гэр хорооллын бүсийн авто замын сүлжээг өргөтгөх, орон сууцны хотхон хорооллын дундах авто зам барих, засварлаж шинэчлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.

3.3.3. Тээврийн хэрэгслийн зогсоолыг нэмэгдүүлж хүртээмжийг сайжруулна.

3.3.4. Нийтийн тээврийн дундын болон эцсийн зогсоолуудыг дулаан зогсоол болон саравч бүхий тохилог орчинтой болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, ая тухтай орчныг бүрдүүлнэ.

3.3.5. Шинээр барих болон өргөтгөн шинэчлэх авто замын дагуу борооны ус зайлуулах шугам сүлжээг төлөвлөн мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

3.3.6. Гэр хорооллын эвдрэл ихтэй, шороон хөрс бүхий гудамж талбайг зохист найрлагатай хайрга, дайрган хучилттай болгон, арчлалт, урсгал засварыг технологийн хугацаанд хийх зохион байгуулалтад шилжүүлнэ.

3.3.7 Дугуйн болон явган хүний замын сүлжээг нэмэгдүүлж, шаардлага хангахгүй болсон дугуйн зам, явган замуудыг засварлан шинэчилнэ.

---oOo---